



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2024 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 194

Улаанбаатар хот

Төрийн өмчид эд хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1, 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 13 дугаар баг, Цамба-2 орон сууцанд байрлах хавсралтад заасан 2 өрөө орон сууцыг төрийн өмчид хүлээн авч, Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газарт эзэмшүүлж, бүртгэлд тусгахыг зөвшөөрсүгэй.

2.Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Г.Ариунбуян, Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газрын дарга дэд хурандаа З.Азат нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Комисс томилон хөрөнгө хүлээн авч, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах,

2.3.Энэ шийдвэрийг Улсын бүртгэлийн байгууллагад хүргүүлж хавсралтад заасан орон сууц төрийн өмч болохыг мэдэгдэх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



132001345

11-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны ... дугаар сарын ... өдрийн
... дугаар тогтоолын хавсралт



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭХ ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн байршил нэр	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ, /бүртгэх үнэ/ (төгрөг)
1	Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 13 дугаар баг "Цамба-2" орон сууцны 1 давхарын 06 тоот 2 өрөө орон сууц	2017	м.кв	54	54,000,000.00
Нийт дүн					54,000,000.00 (тавин дөрвөн сая)